



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 420

Баян-Овоо

Байгууллагын үндсэн хөрөнгөнд
орлого авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралт, 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.2.6, 5.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 253 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2024 оны үр дүнд суурилсан санхүүжилтээр байгууллагын үйл ажиллагааг дэмжин албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор худалдан авсан 12,679,600 (Арван хоёр сая зургаан зуун далан есөн мянга зургаан зуун) төгрөгний үнэтэй 11 төрлийн 24 ширхэг хөрөнгийг тавилга эд хогшлын дансанд орлого болгон бүртгэж авахыг нягтлан бодогч (Э. Өлзийсайхан)-д даалгасугай.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг танилцуулахыг байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн дарга (О. Насанжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ш. ГАНГАНТУУЛ